



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТНОРОВ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 26 өдөр

Дугаар А/ 96

Батноров сум

**Хорио цээрийн дэглэмийг, хязгаарлалтын
дэглэмд шилжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1, 18 дугаар зүйлийн 18.1, 18.4, 18.5, 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2.4, 19.2.7, 19.3.4, 20 дугаар зүйлийн 20.1.1-20.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баянбулаг 4 дүгээр багийн нутаг “Өвөр домбон” гэх газарт нутаглаж байгаа малчин О.Төмөрбаатарын үхэрт аймгийн Мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторийн 2024 оны 06 дугаар сарын 05-ны 24-159 дугаар бүхий хариугаар Галзуу өвчин батлагдаж, 2024 оны 05 дугаар сарын 05-ны А/78 дугаар захирамжийн хүрээнд холбогдох зааврыг хэрэгжүүлж ажилласны үр дүнд өвчлөл илрээгүй тул хэсэгчилсэн хорио цээрийн дэглэмийг бууруулж 2024 оны 06 дугаар сарын 26-ны өдрөөс хязгаарлалтын дэглэмд шилжүүлсүгэй.

2. Хязгаарлалтын дэглэмд шилжсэн О.Төмөрбаатарын малд тогтмол үзлэг тандалт хийж Галзуу өвчинтэй тэмцэх зааврыг хэрэгжүүлж ажиллахыг Энхсүрэг вет мал эмнэлгийн малын эмч (Г.Өсөхбаяр)-д үүрэг болгосугай.

3. Галзуу өвчинтэй тэмцэх арга хэмжээний мэдээ тайланг гаргаж холбогдох газарт хүргүүлэхийг Мал эмнэлгийн тасгийн Улсын байцаагч (Т.Жаргалцэцэг)-д даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Ган-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.



Б.ЖАВХЛАНБАЯР